



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/505

Арвайхээр


Г Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамгаас хамгаалах бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлэх үүргээ зөрчиж архи, согтууруулах ундаа худалдаасан нэр бүхий 1 дэлгүүр, 1 супермаркетын архи, согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрлийг хавсралтаар цуцлаж, хүчингүй болгосугай.

2.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий хавсралтад дурдагдсан худалдааны газруудад хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С. Дуламсүрэн)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101131

Аймгийн Засаг даргын 2020 оны 11  
дүгээр сарын 16-ны өдрийн 21/505  
дугаар захирамжийн хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ  
БУЙ ХУДАЛДААНЫ ГАЗРУУД

№	Дэлгүүрийн нэр	Хаяг	Эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Тайлбар
1.	“Бумбат наран” Супер маркет	Арвайхээр сум, 5 дугаар баг	А.Наранхүү	ЙФ64051517	Хорио цээрийн дэглэм зөрчсөн
2.	“Нарт дэлгэрэх” Хүнсний дэлгүүр	Арвайхээр сум, 6 дугаар баг	Б.Буянтогтох	ЙВ79081301	Хорио цээрийн дэглэм зөрчсөн

-оОо-